

ӨРНӨДИЙНХЭН МОНГОЛЫН ХААДТАЙ ХАРИЛЦСАН НЬ

Д.Уламбаяр*

Чингис хаан XIII зууны эхээр хаяа хаяагаа дэрлэн оршсон олон монгол ханлигуудыг Мөнх тэнгэрийн хүчин дор, өөрийн авъяас билэг, их суу залиар нэгэн өрх гэрт нэгтгэж, эсгий туургатан улс х шударга болсноор монголчууд дэлхийн түүхийн тавцанд бие даан гарч ирсэн нь Монгол ба хөрш орнуудын харилцааны шинж чанарыг хувиргасан төдийгүй Төв Ази, цаашлаад Дорно, Өрнийн олон улсын харилцаанд томоохон өөрчлөлтийг оруулсан билээ. Чингис ба түүний дараахи их хаад тэргүүлсэн монголын тал нутгийн тэнгэрлэг заяат дээд язгууртнууд хол, ойрын хүчирхэг суурьшмал хөршүүдээс өөрсдийн аюулгүй байдлыг сахин хамгаалах, тэднээр төр улсын тусгаар тогтнолоо хүлээлгэн зөвшөөрүүлэхэд чиглэсэн гадаад бодлогыг тууштай баримталжээ. Их Монгол улсын гадаад бодлогын номлол, дипломат ажиллагааны зорилго, чиглэл цаашид боловсрон хөгжихөд тухайн цаг үеийн олон улсын байдал, суурьшмал орнуудын зүгээс Монголын төр улсын талаар баримталж байсан таатай биш бодлого, хандлага хүчтэй нөлөөлж байв. Тиймээс ч Монгол улс хүчирхэгжин мандах явцад дэлхийг нийтээр нь нэг засаг, төрийн мэдэл дор илбэн тохинуулах бодлого явуулах болсон юм. Япон тэнгисээс Адриатик тэнгис хүртэл, Ява Суматари арлаас Байгаль далай ба Саяны уулсыг өнгөртөл өргөн уудам газар орныг эрхэндээ оруулж, цаана нь үлдсэн хэсэгт үлэмж нөлөөтэй болсон тул эзэнт гүрний гадаад бодлого, дипломат ажиллагаа нийт Евразийн олон улсын харилцааны чиг хандлагыг тодорхойлох болж иржээ.

ЗХУ-ын ГЯЯ-ны Дипломатын Академийн захирал байсан, академич С.Л.Тихвинский "Монгол–Татаарууд Ази-Европт"¹ бүтээлдээ бичихдээ Монголын

* МУИС, ОУХС-ийн ахлах багш, докторант

эзэнт улс хүчирхэгжээд 1236 оноос аймшигтай эрч хурдтайгаар энэ үйлийг эхлэв. Умард Хятад буюу Алтан улс 1233 онд, Перс 1231 оноос эзлэгджээ. 1236 онд Камад оршин суудаг түрэг угсаатны Булгаруудын Вант улсыг мөхөөж, 1238 онд Кипчак бууж өгөв. Мөн оны хоёрдугаар сараас Москваг сүйтгэж, 1239 онд Өмнөд Оросын тал нутаг эрхшээлд нь оров. 1240 оны арван хоёрдугаар сард Киевийг сөтгөж, 1240-1241 оны өвөл Польш, Мажарыг эзлэв. 1241 оны гуравдугаар сард Краковыг түймэрдэхэд оршин суугчид нь дүрвэн зайлжээ. 1241 оны дөрөвдүгээр сард 30.000 цэрэгтэй Польш, Загалмайтан Герман, Тейтон морьтны арми нь Лиегнитцийн дэргэдэх Вахльштадтад ялагдав. Дөрөвдүгээр сарын 11-нд Персийг буулган авч ван Бела Адриатик руу зугтжээ. 1241 оны 7 дугаар сард монголчууд Вена хотын дэргэдэх Нейштадт хүрэв. 12 дугаар сарын 25-нд Бат хаан Дунай мөрнийг хөлдүү байхад нь гаталж Гран хотыг эзлэж авсан гэжээ.

Монголчууд юу ч дийлэхээргүй их давалгаа мэт түрэн орж иржээ. Гагцхүү их хаан Өгөөдэй 1241 оны 12 дугаар сарын 11-нд тэнгэрт хальж нэг ёсны "аз" дайраагүй бол тэднийг юу ч зогсоож чадахааргүй байжээ. Энэ түгшүүрт мэдээг Бат хаан 1242 оны босгон дээр Адриатикийн тэнгисийн эрэгт байхдаа хүлээн авчээ. Монгол цэргийн дийлэнх хэсэг даруй буцав.

"Их засаг" хуульд зааснаар шинээр Их хаан их ор суухад алтан ургынхан, цэргийн бүх жанжин, захирагч нар байлцах ёстой байв. Гэхдээ нэг хэсэг цэрэг үлдэж байлдсан нь нэгэнт эхэлсэн үйл хэргээ "додомдох" гэснийх байсан бөлгөө. Монгол цэрэг Бела ванг Хорватад мөшгөж тэрбээр Даламац ольтилог руу зугтаажээ. Тийнхүү монголчууд Сплато, Катторо хүртэл түрж, дараа нь бүрмөсөн нутаг буцжээ.

Гуравхан жилийн дотор Дорно зүгээс нэр нь үл мэдэгдэх "буруу номтон" морьтон нүүдэлчид хуй салхи мэт түрэн орж ирэн Дорнод Европыг эрхшээлдээ оруулж, бүтэн нэг тивийн улс орныг ялаад Герман, Италийн хаалгыг тогшиж эхэлжээ.

Ахар хугацаанд монголчууд түрэн орж ирсэн нь Өрнөдөд Атиллагийн түрэмгийллээс хойш тохиолдоогүй аюул нүүрлэсэн нь энэ юм.

К.Маркс "XVIII зууны дипломатын түүхийн нууц" бүтээлдээ бичихдээ: "Энэ талхидал зүгээр нэг дарлал байсангүй, тэд ард түмний сэтгэл зүрхийг гутаан доромжилж, сүйтгэн хохироож байв... татаарчууд үгүйрэл хоосрол, нийтийг

¹ С.Л.Тихвинский. *Татаро-Монгольские завоевания в Азии и Европе: Татаро-Монголы в Азии и Европе* (под ред. С.Л.Тихвинский) изд. 2-е М., 1977, с.36-38

хамарсан аллагыг ердийн үзэгдэл болгосон зохион байгуулалттай алан хядах (террор) дэглэм тогтоосон” гээд монголчуудыг “аж төрөх цэрэг ёсны үр дүнд хагас иргэншсэн ард түмэн”² гэж нэрлэсэн байна. Зөвлөлтийн ба өрнөдийн түүх бичлэгт ноёрхсон энэ мэт үнэлэлт, дүгнэлтийг нэрт түүхч, доктор Л.Н.Гумилёв олон арван жилийн түүхийн судалгааныхаа үр дүнд залруулсан билээ³. Монгол-татаарууд догшин ширүүн дайсантайгаа ердөө л илүү гарамгай байлдсан хэрэг. Ингэлээ гэж тэднийг зэмлэх нь шинжлэх ухаанд харш гэдэг нь өнөөдөр ойлгомжтой юм. Доктор Л.Н.Гумилёв түүхийг үзэх үзэл, судалгааны арга зүйд шинэтгэл хийж үндэстэн үүсч бүрэлдэн хүчирхэгжихэд угсаатны үйл явц, эрчим хүч, хэмнэл, амь мандал, түүхэн газарзүй чухал болохыг тэмдэглээд түүхийг нийгмийн болон байгалийн талаас нь хамтад нь авч судлахын чухлыг онцолжээ. Өрнөдийн түүхчид, тэр ч байтугай К.Маркс ч уг асуудлын түүхэн учрыг олоогүй юм гэж тэрбээр бичжээ.

Герман үндэстний Ариун Ромын эзэнт улсын хаан II Фредерик 1241 оны татааруудын ниргэлтийн дараа өрнөдийнхнийг эв нэгдэлд уриалан дуудсан боловч түүний үгийг олигтой тоосонгүй ажээ. Тэрбээр Ромын Пап IX Григоритой зөрчилтэй байснаас Италийг огоороход хүрч түүнчлэн Мажар, Польшид ч тусламж хандуулж чадахааргүй байв. II Фредерик Английн ван, хадам ах III Хенрид захидал илгээж эв нэгдэлд уриалжээ. Францын их сургуулийн профессор, дундад зууны түүхийн нэрт эрдэмтэн Клод-Клэр (Claude-Claire) ба Ренэ Каплер (Rene Kappler) нарын Жан де Плано Карпиний Монголчуудын түүхийн тэмдэглэлийн эртний латин хэлнээс хийсэн эцсийн бүрэн гүйцэд хөрвүүлгийн удиртгалд II Фредерикийн захидлаас иш татан тэмдэглэхдээ: “...Төрийн ихэс дээдчүүлийн хооронд энх амгалан ертөнцөд зөвхөн гай зовлонг л авчирч байсан хэрүүл маргаан дуусгавар болох ёстой...” Бидний бодоход чингэх цаг иржээ. Юун хэмээвээс ертөнц эв түнжингүй салангид болж, Бурханы сургаалыг түгээж, бататгах үүрэгтэй баймаар олон хүний зүрхний хайр ихэд хөржээ...” гээд Герман, Франц, Испани болон Англи нэгдэн зэвсэглэн тэмцэх ёстой. “Христийн сургаалыг түгээж бататгах ёстой баймаар” самууны эздийн вант улс Италийг дурдалгүй тэднийг харин өөрсдийнх нь үйл хэргийг бусниулахаар хамаг цагаа барж байна гэжээ. II Фредерик захидалдаа цааш нь бичихдээ монголчуудыг “босоо орболон” гэж нэрлээд хүйс тэмтрэлт, “урьд өмнө

² Marx K. *Secret Diplomatic History of the Eighteenth Century*. London., 1899. pp. 78-80, Маркс К.

Разоблачения дипломатической истории XVIII вв. Жур: Вопросы истории. 1989. №1-4

³ Гумилев Л.Н. *Апокрифический диалог Жур: “Нева”*. 1988. №3-4. *Этногенез и биосфера земли*. Л., 1989. *География этноса в исторический период*. М., 1990. *Ритмы Евразии* М., 1993

хэзээ ч үзэгдээгүй цусан далай", аймшиг түгшүүрийг түгээж яваа "тийрэнгийн цэргүүд"-ийн бараг л хүмүүн төрөлхтөнд байдаггүй шинж төлөвийг дурдсан байна. "Тамын хөвгүүд болох татаарууд гэнэт тэнгэрийн хилэн, гал цахилгаан адил гарч ирлээ"⁴ гэжээ. Үнэндээ их хаан Өгөөдэй тэнгэрт халиагүй бол Өрнөд Европ ааг омгондоо багтаж ядсан "буруу номтон" Монгол-татаарчуудтай нэгдмэл хүчээр тэмцэж чадахааргүй байв.

Гэхдээ зарим ихэс дээдэс хөл дороо газар хөдлөхийг мэдэрчээ. 1243 онд IX Григорийг залгамжилагч IV Инносен Ромын Папын ширээнд заларч улмаар тэрбээр 1245 оны 6 дугаар сард Лион хотноо XIII дахь удаагийн "Христийн ертөнц дахины их чуулган" зарлан хуралдуулж тус чуулганаар Монгол-татаарын довтолгооноос Өрнө дахиныг хамгаалах зорилгоор загалмайтны аян дайныг монголчуудын эсрэг зохион явуулах тухай асуудлыг авч хэлэлцсэн байна.⁵

Папын энэ төлөвлөгөө биелэгдээгүй боловч IV Инносен монголчууд Өрнө зүг үнэхээр дахин довтолж гэж байгаа эсэхийг баттай тодруулах, тэдний цэрэг, зэвсгийн хүчийг тагнан турших зорилгоор тийнхүү Франсуа гэгээнтний сургаалын гэлэн, итали гаралтай Жан де Плано Карпиниар (1182-1251) /Johann de Plano Carpini/ толгойлуулсан элч төлөөлөгчдийг Монголын эзэнт гүрний голын улсад илгээжээ. 60 гарсан гэлэн тэрбээр урьд нь Папын зараалаар Герман, Испанид очиж байсан туршлагатай нэгэн бөгөөд 1245 оны 4 дүгээр сарын 16-нд Лион хотыг орхин гарчээ.

Папын элч нар 1246 оны 4 дүгээр сарын эхээр Ижил мөрний адагт Бат хантай уулзаж улмаар 4 сар аялсны эцэст сая Хархорумд хүрэлцэн иржээ. Плано де Карпини Гүюгийг хаан ширээнд залрах ёслолд оролцсон бөгөөд тэр тухайгаа айлтгалдаа өгүүлжээ. Тэд их хааны хүрээнд гурван сар хагас болоод 1246 оны 11 дүгээр сарын дундуур Хархорум хотоос хөдөлж, 1247 оны 5 дугаар сард Батын өргөөнд хүрч, тэндээс Киевийг дайран эх нутагтаа эгэж иржээ.

Плано де Карпинийг буцаж ирмэгц илтгэлийг нь Ромын Пап болон Ватиканы ихэс дээдэс ихэд олзуурхан сонирхожээ. Энэ тухай түүнтэй 1247 оны 11 дүгээр сард Их хамбын өргөөнд уулзсан Фра Салимбен он цагийн тэмдэглэлдээ гэрчилж бичсэн байна. Сайхь тэмдэглэл нь монголчуудын талаархи нэлээд ач холбогдол бүхий анхны бичгийн дурсгал ажээ.

⁴ Гийом де Рубрук. Монголын эзэнт гүрэнд зорчсон нь (1253-1255) орч. Т.Төмөрхүлэг УБ., 2000, 35 дахь тал

⁵ История дипломатии. Том I. М., 1959, с.132

Плано де Карпини айлтгалынхаа оршилд явсан учир шалтгаан хийгээд илтгэлийнхээ зорилгыг тодорхой бичсэн юм.

Бид Апостолын өргөөнөөс (Ромын Папын өргөө) лүндэгнэн даалгаснаар татаар болон дорно дахины бусад улс иргэн рүү зүглэхдээ Эрхэм дээд Пап хийгээд хүндэт их хамба нарын хүсэл зоригийг сайтар ухан мэдэж, Дээд тэнгэрийн сүмийг маань мөдхөн ирж сүйтгэх нь хэмээн та бүхний эмээж байсан Татаарт юуны өмнө очихоор шийдсэн билээ. ... Бид бүхэн татааруудын хүсэл зориг, цаад бодлыг тандан мэдэж гэмээнэ тэднийг Христ шашинтнуудад нээн таниулах зорилгоор, бас улс амьтны нүглийн сав дүүрсний гайгаар урьд өмнө тохиолдсон шиг түрэмгийлэгчид хөөрхийлөлттэй тэдэн рүү бүү уулгалан довтлоосой, христ түмнээр битгий махан овоо босгоосой гэсэндээ нийт Христ шашинтнууддаа тус хүргэхийн үүднээс бие сэтгэлээ хайрлаагүй билээ.

Ийнхүү та бүхнийг сэрэмжлүүлэх зорилгоор та бүхэнд хэрэг болох болов уу гэж бүтэн жил, дөрвөн сар тэдний дунд, тэдэнтэй хамт бядан явж, нэг доор аж төрөхдөө өөрсдийн нүдээр үзсэн буюу бидний тухайд бүрэн итгэж болох олзлогдсон Христ мөргөлтнүүдээс сонсч мэдсэн бүхнээ тоочин бичсэн болох тул та бүхэн үүнийг бат нутаар итгэх ёстой болов уу⁶ гэжээ.

Плано де Карпинид нутаг буцахын өмнөхөн их хааны бичгийн сайд болон олон бичээч нар Ромын Папад илгээх Гүюг хааны жуух захидлын эхийг латин болон перс хэлэнд олон удаа тайлбарлан хэлж орчуулан бичиг хавсарган өгчээ.*

Ромын Пап Монголын “хааныг христос шашинд орохыг сургамжлаад” гэм буруугүйн дээр гэм тавих санаагүй Мажар, Польш иргэдийг алж хядсанд гайхаж” байгаагаа илэрхийлээд түүнд тэнгэр бурхан хилэгнэж байгаа тул цаашид эл явдлаа бүрмөсөн огоорч, нүглээ наминчлахыг сануулсанд” их хаан Гүюг ихэд уурсаж илгээсэн захидалдаа түүнийг “ухаж ойлгосонгүй” хэмээн Папын сургамжийг эрс няцаагаад “Мөнх тэнгэрийн хүчин дор наран ургахуй зүгээс наран шингэх хүртэл бүх газар орон бидний ивээлд орсон... Эдүгээ та нар иргэн чинь болж эд агуурс юугаа өгтүгэй хэмээн чин шудрагаар өгүүлбээс зохино... Энэ үеэс эхлэн бид та нарыг ивгээл дороо орсон хэмээн үзсүгэй. Хэрэв та нар тэнгэрийн бошгийг үл даган, ману

⁶ *Plano di Carpini (Johann de), Storia dei Mongoli, Spolete, 1989, pp. 11-12.*

Плано Карпини. “Монголчуудын түүх” УБ., 1988. 9-10 дахь тал

* Ромын папын элчийн авч очсон Гүюг хааны бичиг гагцхүү перс эхээрээ Ватиканы архивт хадгалагдан үлдсэнийг 1920 онд Польшийн эрдэмтэн лам Крилл Каралевский анх нээн олж фотоогоор хуулбарлан авч олны хүртээл болгосныг судлаач Массэ, эрдэмтэн П.Пеллио нар судалж орчуулан нийтэлжээ.

зарлигийг эсэргүүцэх аваас дайсан минь болно... юу болохыг гагцхүү тэнгэр мэдтүгэй”⁷ гэж заналхийлгэн төгсгөөд “Мөнх тэнгэрийн хүчин дор их Монгол улсын Далай хаан зарлиг ил болга иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай”⁸ хэмээсэн монгол үсгээр сийлбэрлэсэн тамга даржээ.

Монголын их хаан Плано де Карпинийг хүлээн авч уулзаж, зорьж ирсэн хэрэгтэй нь танилцаад Ромын Папад хариу элч илгээх бодлоготой байв. Гэхдээ их хаан Гүюг элч нараа Папад илгээхийг Плано де Карпиниар өөрөөр нь гуйлгуулахыг аль болохоор оролдож байжээ. Тэд Монголын тагнуул туршуулуудыг нутагтаа авчирсан хэрэгт орохоос эмээн болгоомжилж, хааны жуух захидлыг өөрийн эзэн Папад үнэнч шудрагаар дамжуулан өгөхийг амалж, элч довтлох явдлыг болиулсан байна⁹.

1245 онд Ромын Пап IV Инносен мөн Персийн захирагч, монгол жанжин Байжуд доминикан сургаалийн гэлэн Николас Аскелин тэргүүлсэн элч төлөөлөгчдийг илгээсэн нь дээрх Гүюг хааны захидалтай утга ижил хариуг авчирчээ. Гэлэн Николас Аскелин дипломатын ур чадвараар тааруухан нэгэн байсан бололтой. Монгол заншлаар элч төлөөлөгчид нэг бус хоёр өвдгөөрөө сөхөрч суух ёстой байв. Христос шашинтнууд зөвхөн бурханд хоёр өвдгөө нугалж мөргөдөг. Мөн ван юмуу төрийн ихэс дээдэст ганц өвдгөөрөө сөхөрч суун хүндэтгэл үзүүлдэг ажээ. Татаарууд нэгэнт л христос шашинтан бус учраас Аскелин энэ шаардлагыг хүлээж авахгүй гэжээ. Татаарууд уурлан хорсч “та нар шиг Христ мөргөлтөн, нохойн гөлөг болоод яах юм. Танай Пап лам бол нохой, та нар цөмөөрөө жинхэнэ ноход” гээд цээрлүүлэх саналын дотор “Аскелинийн арьсыг нь хуулж, өвсөөр орлуулан наагаад Пап ламд нь буцаах” гэсэн сэдлэг байжээ¹⁰. Сүүлчийн мөчид тайвширцгаасан монголчууд элч нарыг Байжугийн хүрээнд удаан хугацаагаар харгалзаанд байлгаж тэгээд ч тэд их хаантай уулзаж чадалгүй Байжугийн Пап ламд хандсан захидлыг авч буцацгаасан байна. Уг захидалд: “Их хааны зарлигаар Байжу бивээр танд энэхүү хариуг явуулж байна. Пап аа, таны захидлыг авч ирсэн элч тун ч бардам дуугаар ярьж байна. Таны зарлигаар тэгсэн үү, бүү мэд. Та биднийг олон хүн аллаа гэж зэмлэж байна. Гэвч биднийг үг дуугүй дагасан бүхэн газар дээрээ эзэн болж үлдэнэ, эсэргүүцсэн бүхэн устгагдана гэсэн энэ ертөнцийн эзэн Тэнгэрийн

⁷ Pelliot. Paul. Les Mongols la Papante, Paris, Revue de L'Orient chretien, 3-e serie, T.3 (XXIII) 1922-1923, pp.3-30

⁸ Плано Карпини ... 89 дэх тал

⁹ Мөн тэнд 77 дахь тал

¹⁰ Гийом де Рубрук36 дахь тал

зарлигийг санагтун. Би Пап чамд тэнгэрийн зарлигийг явуулж байна. Чингэхлээр хэрэв газар нутгаа барьж үлдье гэж бодож байгаа бол биеэрээ бидэн дээр ирж бүх ертөнцийн эзэнтэй нийцэн явах ёстой. Хэрэв та үгүй гэх аваас юу болохыг бид мэдэхгүй, зөвхөн Тэнгэр мэднэ”¹¹ гэж сүрдүүлэн өгүүлжээ.

Папын элч, өвгөн гэлэн Лионд буцаж ирснийхээ дараахан үзэж харсан, тагнаж мэдсэн зүйлийнхээ талаар илтгэл, тэмдэглэл бичсэн нь бидний үед уламжлагдан ирсэн бөгөөд Монголын гадаад харилцаа, дипломатын түүхийн чухал сурвалжийн нэг болж байна. Плано де Карпини Татаарын санаархал Чингис хааны зарлиг ёсоор болж өгвөл бүх дэлхийг эрхшээлдээ оруулах явдал болой. Тийм ч учраас тэдний хаан нь зарлигтаа “Тэнгэрийн гэсгээлч, далай хаан” гэх ба түүний тамгын бичээс нь “хөхрөгчид тэнгэр, хөрстөд тэнгэрийн гэсгээлч Гүюг хаан, Далай хааны тамга”¹² хэмээсэн байдаг. Тийм ч учраас дээр өгүүлсэнчлэн эрхшээлдээ ороогүй хэнтэй ч бол найрамддаггүй билээ. Одоо дэлхий дээрх христос шашинт улс орныг эс тооцвол өөр тэдэнд эзлэгдээгүй нэг ч улс гүрэн байхгүй болсон учир тэд бидний эсрэг тулалдаанд бэлтгэж буй.

“Их Пап хийгээд хаад, ноёд болон өрнө дахины христос шашинтан бүх ард түмэнд буулгасан зарлиг тушаалыг эс дагаваас! ” хэмээн тэрхүү Гүюг хаан олон ноёдынхоо хамт бурханы сүм хийд ба Ромын эзэнт улсын эсрэг, христос шашинтан бүх улс орны эсрэг, өрнөдийн ард түмний эсрэг тугаа хандуулан өргөж байна” гэсэн түгшүүрт мэдээг Ромын Папад уламжилжээ.

IV Инносенээс Персийн захирагч монгол жанжин Байжуд илгээсэн гэлэн Николас Аскелин тэргүүлсэн элч төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон Симон де Сен Кентин ч Карпиний бичсэнтэй төстэй зүйлийг өөрийн аян замын тэмдэглэлдээ бичиж үлдээжээ.¹³

Элч Плано де Карпини Монголын довтолгооны эсрэг христос шашинтны бүх улс орон нэгдмэл хүчээр хамтран тэмцэх хэрэгтэй гэсэн саналыг Папад мөн дэвшүүлэн тавьжээ. Тэр бичихдээ: “Монголчуудаас аврагдана гэж европ “ах дүү” нараа орхих бол эндүүрч байгаа хэрэг. Монголчууд тэднийг байлдааны тэргүүн шугаманд тууж, дараа нь боолоо болгоод эсвэл ална. Аль нэг орон өөрийнхөө хүчээр тэдэнтэй тулалдахын тухай санахын ч хэрэггүй. Хэрэв Христ шашинтнууд

¹¹ Saunders J.J. *Mongol imperialism*. Berkeley, California, 1987, p.99

¹² Плано Карпини ... 50 дахь тал

¹³ Плано Карпини ... 92 дахь тал

өөрсдийгөө, улс орноо, христ ертөнцөө авръя гэж бодож байгаа бол ван, хунтайж, барон болон бүх улсуудын тэргүүн нар нэгдэж тэднийг дэлхий даяар тархаж эхлэхээс өмнө дарж авах зорилгоор нэгдмэл хэлэлцээрээр цэрэг илгээх хэрэгтэй.... Эсвэл нэгдэх, эсвэл үхэх. Ухралт гэж байж болохгүй. Бултаж зугтаах явдал гэж байж таарахгүй. Тэднийг мохоох боломжгүй гэж үзэж болохгүй. Гагцхүү аргаа л сайн бодох хэрэгтэй. Хамгийн гол нь эв нэгдэл, зохих зэр зэвсэг юм. Сэтгэл санаа, бие махбодь, эрх чөлөө хийгээд бусад бүх зүйлээ хамгаалахын тулд зэр зэвсэг олоход мөнгөнд гар татах ёсгүй” гэжээ.

Тийнхүү “Христ дахины улс” байгуулахаар тэмцэж байсан Ромын Папын улс ба Монголын эзэнт гүрэн хоёрын дэлхийд ноёрхох гэсэн ашиг сонирхол тулгаран мөргөлдөж, бие биеэ эрхшээл нөлөөндөө оруулан авахыг эрмэлзэж байсан нь тодорхой билээ.

Гэсэн хэдий ч нижгээд жилийн дотор Дорно-Өрнийн олон улсын харилцааны чиг хандлага, шинж чанар өөрчлөгдсөн нь Монголын эзэнт гүрэн лалын ертөнцийг өөрийн эрхшээлд оруулсан явдал юм. Монголын эзэнт гүрэн, Өрнөдийн харилцаа сайжирсан нь Христийн ертөнц лалын шашинт арабуудын эсрэг загалмайтны аян дайн хийж байсантай шууд холбоотой бөгөөд энэ нь Монголын Юан гүрний хаан Хубилай, Ойрхи дорнодод ноёрхож байсан Хүлэгү, түүний удмын Ил хаадын бодлоготой нийцэж байсанд оршино.

Хубилай хаан юуны урьд Иерусалим төвтэй лалын шашны гол орнуудыг эзлэн авах арга замыг эрэлхийлж, христос шашинтан Өрнөд Европын орнууд, ялангуяа Ромын Паптай эвсэл холбоо байгуулахыг ихэд эрмэлзэж тэр зүгт олон удаа элч зарж байсан билээ. Хубилай хаан Европын орнуудад элч довтолгохдоо эрдэм мэдлэг бүхий тухайн орнуудын иргэдийг өргөн оролцуулдаг байжээ. Тухайлбал Юан улсад анх худалдааны хэрэг зоригоор Зүүн татаарын (Ил хаадын улс Д.У.) хаан Хүлэгүгийн элчдийг дагалдан ирсэн Италийн Венец хотын ах дүү худалдаачин Николай Поло, Матвей Поло нарыг Хубилай хаан өөрийн итгэмжит элч болгон зарж байв. Ах дүү Поло нар 1260 оны дунд хэрд Ханбалиг (Бээжин) нийслэлд хүрэлцэн ирэхэд Их хаан ихэд хүндлэн, баяр найр хийн угтаж, тэднээс олон зүйлийг лавлажээ. Хаадыг нь асууж, тэд улс орноо хэрхэн засан захирч, хууль цааз, шүүх таслахыг яахин хэрэглэдэг, Апостол буюу Пап ламтан хийгээд Ромын шашны үйл хэрэг, латинчуудын зан суртлыг сураглан асуужээ. Хубилай хаан тэднийг Когатала хэмээгч монгол түшмэлийн хамт элчээр томилон Ромын Папад илгээхээр шийджээ.

Элч нарт хааны алтан пайз гэрэгэ шийтгэн олгож Папад хүргэх их хааны жуух бичгийг түрэг хэлээр үйлдэн гардуулж амаар дамжуулах үгийг захижээ. Бэлэг болон ам захиа тэргүүтний утга нь дараахи мэт байв. Үүнд: Их хаан Ромын Папад долоон эрдэмд мэргэшсэн христос шүтлэгтэн зуун ламтанг Юан улсад ирүүлэхийг хүсч мөн түүнчлэн Иерусалимаас христос бурханы шарилын зулаас тос авчрахыг элч нартаа Их хаан бас захижээ.¹⁴

Николай Поло, Матвей Поло нарыг Ромд ирэхэд таалал төгссөн IV Климент Папын оронд өргөмжлөгдсөн Пап Григорий Пьяченцкий хүндэтгэн хүлээн авч буцаахдаа цэцэн мэргэн, ном тавигч Николай Виченцкий, Гильом Триполийский хэмээгч хоёр гэлэнг жуух захидал, ам захиасын хамт Монголын элчийг дагуулан Хубилай хаанд илгээн явуулжээ. Ромын Папын хоёр элч мамлюкуудын довтолгооноос айж замаасаа буцжээ. Гэвч ах дүү Поло, Николай Пологийн хүү Марка Пологийн хамт Ромын Папын бичиг захидлыг Хубилай хаанд өргөсөнд хөлтэй найр хуримаар угтжээ. Тэд хааны ордны дэргэд 17 жил суухдаа Хубилай хаанд нэн дотночлогдож, ялангуяа залуу хүү Марко Поло монгол хэл бичигт нэн сайн сурч, Их хааны тэргүүн шадар түшмэл болж олон газар оронд Монголын элчээр томилогдон явж байжээ. Ер нь Хубилай хааны элчин харилцаанд Марко Поло чухал үүрэг гүйцэтгэж байсан нь түүний аян замын тэмдэглэлээс тодорхой харагддаг билээ. Поло нарыг нутаг буцахад нь Хубилай Перс дэх Монголын Ил хаан Аргунд өөрийн удмын бэр хүргүүлэхээр заржээ. Түүнчлэн Их хаан тэднээр дамжуулан Ромын Пап, Франц, Испани болон бусад христос шашинт орнуудын хаадад жуух захидал илгээж явуулсан байна. Хубилай хаан Николай, Матвей, Марко гуравт шонхор, арслан дүрст хоёр алтан пайз, нэг энгийн пайз олгож 14 дарвуулт хөлөг, үлэмж тооны бараа бологчидтой илгээжээ. Энэ нь Монголын их хаан Өрнө зүгт илгээсэн өөрийн элч нарын үүрэг даалгаврыг дээд зэргээр үнэлэн үзэж, тэдэнд хааны бие төлөөлөгчийн онцгой эрх ямба олгосон хэрэг байв.

Монголын эзэнт гүрний хил Ойрхи Дорнод, Өрнөд Европт тулж очсон нь лал, христийн ертөнцтэй шууд харилцах боломжийг өргөжүүлсэн билээ. XIII зууны II хагасаас Монголын эзэнт гүрнээс Өрнөдтэй харилцах хэргийг Иран, Ирак,

"Долоон ухаан" гэж уран үг, нотлохуйн ухаан, дуун ухаан, тоон ухаан, зурхай, хөгжсөм, газар зүй зэргийг дундад зуунд нэрлэдэг байжээ

¹⁴ Pelliot Paul. *Notes on Marco Polo, Paris. Imprimerie Nationale et Adrien-Maisonnave, 3 vol. T.I. 1959; T II 1963, T III 1973. pp. 5-18. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987, 5-18 дахь тал*

Азербайжан, Армен, Туркестан, Гүржийн нутагт тогтсон Ил хаадын улс, Хүлэгү, түүний удмынхан шууд гардан хийж, зуучийн үүрэг гүйцэтгэж байжээ.

Тулуйн хүү, Их хаан Мөнхийн дүү Хүлэгүгийн байгуулсан Ил хаадын улсын бие даасан байдлыг Монголын эзэнт гүрний их хаан Хубилай 1261 онд хүлээн зөвшөөрсөн юм.

Египетийн султануудтай хийсэн тэмцэл, Алтан Ордны монгол хаадтай газар нутаг булаалдан олон жил байлдах явцад Өрнөд Европын христосын шашинт улсууд болох Генуя, Франц, Английн хаад, Ромын Паптай Ил хаадын улс холбоо тогтоож элчин солилцож байв. Энэ нь Монгол төрийн тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хамгаалахын төлөө хийсэн идэвхтэй гадаад бодлогын үр дүн байв. Өрнөдийн улсуудтай Сири, Палестинийг хүч хавсран эзэлж улмаар тэдгээр нутгийг загалмайтанд өгөхийг амлаж, христос шашныг хүндэтгэн үзэж, эв найртай байхын чухлыг илэрхийлж байжээ. Тухайн үед Ромын Пап IV Климент, Английн ван I Эдуард нар Абага хаанд захидал илгээн харилцаж байлаа. Хүлэгүгийн хүү, ширээ залгамжлагч Абага хаан 1265-1288 оны хооронд төр барьж байх цаг дор Өрнөдтэй харилцаж байсныг гэрчлэх нэгэн баримт бичиг уламжлагдан ирсэн нь Абага хаан католик шашны элч нарыг нутаг буцахад нь олгосон үнэмлэх бичиг бөгөөд 1921 онд Ватиканы нууц архиваас олджээ. Сайхь бичгийг “туулай жилд бичив” гэснээс үзэхэд 1267 юм уу, 1279 оны аль нэгэнд бичсэн бололтой. Утга нь, Ром хот хүртлэх өртөө замд яваа Папын эрхэм элч нарт хоол хүнс, ундаа жүүс, унаа хөсгөөр дутаахгүй хангаж, хүч үл хэрэглэхийг даалгасан байна.¹⁵ Өрнөдийн ихэс дээдэс Монголын элч төлөөлөгчид, түүний дотор Их хаадын элч нарыг олон удаа хүлээн авч байсан мэдээ Ватикан, Франц, Английн хаадын архивт хадгалагдан үлджээ.

Эх сурвалжаас үзвэл Абага хааны хүү, Ил хаан Аргун өрнө зүг дөрвөн удаа элч довтолгосны анхных нь 1285 онд хамаарагдаж байна. 1285 оны 4 дүгээр сарын 2-нд өргөмжлөгдсөн Ромын Пап IV Хонориягийн архивт Ил хаан Аргунаас Пап ламтанд илгээсэн захианы эх анх удаагаа алдарт Баронийусын “Анналесын он дараалсан бичиг”-т орсон байх бөгөөд Абел-Ремюза 1824 онд анх тодруулан судалсан байна.¹⁶

¹⁵ Cleaves F.W. *A Chancellery Practice of the Mongols in the Thirteenth and Fourteenth Centuries*. *Harvard Journal of Asiatic Studies*. Vol.IV.1951,pp.493-526+2pl.

¹⁶ Abel-Remusat, *Memoires des Relations politiques des princes chretiens des rois de France, avec les empereurs Mongols, Second Memoire. Relations diplomatiques des princes chretiens avec les rois de Perse de la race de Tchinggis, depuis Houlagou, jusqu'au regne d'Aboussaid dans l'histoire et Memoires de l'Institut Royal de France, Academie des Inscriptions et Belles-lettres VII, Paris,1824*. Козин С.А. *Вопросы о дешифровании*

1285 оны элч төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Иза, Богагок, Менгилик, Фома Банхринус, Угето хэлмэрч нар оржээ. Анхны элчдийн зарим нь дараагийн элчдийн бүрэлдэхүүнд орж байсан явдал тэд тухайн цаг үеийн мэргэжсэн дипломат элч, гадаад хэл, газар орныг сайн мэдэх хүмүүс байсан нь тодорхой юм. Захидлын эхэнд Аргун хаан Папад мэнд дэвшүүлж “Бүх татаарын анхны эцэг Чингис хаан” христос шүтлэгтэнд албан татвар ногдуулдаггүй, тэд бүгдэд эрх чөлөө олгосныг дурдан, Папад бэлэг сэлт илгээн сайн сайхныг хүсч байгаагаа илэрхийлсэн байна. Цааш нь өгүүлэхдээ өвөг эцэг хаан Хүлэгү, эцэг Абага хаан өөрийн газар нутаг дээрх христос шүтлэгтнийг хамгаалж байсан ба энэ нь танд таалагдах болов уу” хэмээжээ. Ил хаан Аргун өөрөө мөн христос шүтлэгтнийг хамгаалж тэдэнд найрсаг хандахаа илэрхийлсэн байна.¹⁷ Энд тэмдэглэхэд академич Б.Я.Владимирцов “Их хаан христосын шүтлэгтэн байгаагүй, харин эзэнт улсдаа, бүр алтан урагтаа, өөрийн хишигтэн цэрэгтээ, тамгын газартаа ч христос шүтлэгтэн, лал болон бурхны шашинтан хэнийг ч ялгалгүй хүлцэн байлгадаг байсан юм¹⁸” гэж бичсэн байна.

“Их засаг” хуулиар бөөгийн мөргөлийг ивээн хамгаалж, төрийн гол шашин болгохын хамт сүм хийд, шашны мөргөл үйлдэгчдийг хүндэтгэн аливаа албан татвараас чөлөөлдөг, харь улсын шашин шүтэгчийг өөрийн оронд чөлөөтэй байлгах явдлыг хуулиар хамгаалж байсан нь¹⁹ утгаа нарийн учир холбогдолтой байжээ. Аргун хааны захидлын гол зорилго нь монгол, христос шашинтныг зааглаж байгаа Сарацины (Сири Д.У) нутаг руу хамтран довтлох, эзэлсний дараа хувааж авах явдал байв.

Ил хаан Аргун 1287 онд Ромын Папад илгээсэн хоёр дахь элчээ несторион шашинт уйгар ламтан Раббан Саумаар удирдуулан довтолгоожээ. Элч төлөөлөгчдийн зорилго анхныхтайгаа адил байсан нь Саумын өөрийн бичиж үлдээсэн тэмдэглэлээс тодорхой ажээ. Тэрбээр бичихдээ “Хаан бол католикийнхантай найрамдалтай учраас Палестин, Сирийн нутгийг эзлэн авах хүсэлтэй бөлгөө. Иерусламыг эзлэхэд та бүхний тусламжийг хүсч байна гэж Византийн хаанд уламжилсан” хэмээжээ. Элч нар Константинополд Византийн хаан II Андроникус, Италид хүрч Ромд Пап IV Николас, Франц орж Парист IV гоо Филипп, Англид ирж I Эдуард нарт бараалхан

дипломатических документов монгольских ил ханов. Изд. Акад. Наук СССР, часть социальных наук, 1935, с. 645-655

¹⁷ Ibid.

¹⁸ Владимирцов Б.Я. Чингис хан. Берлин, СПб., М., 1922, с. 18

¹⁹ Рязановский В.А. “Великая Яса” Чингис Хана. Харбин., 1933, с. 67

Ил хаан Аргуны бичиг захидал, бэлэг сэлтийг өргөн барьж яриа хэлэлцээр хийгээд буцаж иржээ.

Английн ван захидлыг хүлээн авч баярлаж хэлэхдээ: “Хүзүүндээ загалмай зүүсэн хаад бидэнд Иерусламыг эзлэн авах яриа өрнүүлэхээс өөр сайхан зүйл юу байхсан билээ. Миний сэтгэл санаа уужирч буйгийн учир нь Аргун хаан мөн тийм бодолтой байгааг дуулсан явдал юм”²⁰ гэжээ.

Ил хаан Аргун өрнө зүгт илгээсэн гурав дахь элчийг хааны шадар туслагч, Генуягийн Мускерил де Жизолф тэргүүлжээ. Энэ элч хааны дипломат даалгаврыг ёсоор болгож байсны учир 1291 онд дахин элчээр зарагдаж байжээ. Хожим нь ч 1302 онд Аргун хааны хүү Газан хааны зараалаар өрнөдөд очиж байсан юм. Мускерил де Жизолф элчийн зорилго нь “Ариун газрыг” чөлөөлөхийн тулд Ромын Пап, Франц, Английн хаадаас дэмжлэг хүсэх явдал байв. Мускерил де Жизолф Ромоос Парис орж, Францын IV гоо Филиппэд Аргун хааны захидлыг өргөн барьсныг тусад нь өгүүлэх бөлгөө.

Ил хаан Аргуны элч Мускерил де Жизолф Ромд байхдаа “татаарын их хаан Аргуны элчийг” хүлээн авахыг Английн ван I Эдуардад хүссэн Папын бичиг авч явжээ. 1290 оны нэгдүгээр сард Мусерил де Жизолф дагалдагсдынхаа хамт Лондонд хүрэлцэн очиж, Аргун хааны бичгийг гардуулжээ. Аргун хаанаас Английн ванд илгээсэн бичгийн эх нь уламжлагдан ирээгүй боловч Аргун хаанд I Эдуард вангаас явуулсан хариу захидлын хуулбар үлдсэн байна. Түүндээ Аргун хаан үнэхээр дайтахыг урьдчилан төлөвлөж байгаа бол хааныг бүх талаар дэмжихээ илэрхийлж аян дайнд явах цаг хугацааг Аргун хаанд мэдэгдэнэ хэмээн амласан байна.

Аргун хаанаас Өрнөдөд явуулсан дөрөв дэх элчийн тухай мэдээ баримт мөн уламжлагдан иржээ. Энэ нь юуны өмнө 1290 оны Өрнө зүг явж байсан Цагаан (Заган)-ы тухай бичиг баримт юм. Аргун хааны Цагаанаар толгойлуулсан дөрөв дэх элчийн бүрэлдэхүүнд мөн Мусерил, Сабадинус нар оржээ. Тэд Европт 1290-1291 онуудад аялсан байх бөгөөд тэдний зорилго түрүүчийн адил байжээ.

1290 оны 5 дугаар сард Аргун хаанаас Ромын Пап IV Николаст илгээсэн бичиг нэн сонирхолтой юм. “Ил хааны эзлэн суугаа нутагт аливаа хүн бүгд өөрийн ном бичгээр шашнаа шүтэн буй. Христосын ном тэнгэрт тайгч нь үнэн билээ. Эцэг тань христосын номд үнэнч, эмэг тань сахилтай байсан бөлгөө. Христосын шашинд орох ажаамуу” гэсэн Папын захидлын хариуд Ил хаан Аргун илгээсэн бичигтээ:

²⁰ М.И.Гольман. Изучение истории Монголии на западе XIII середина XX вв. М., 1988, с.205

“Чингис хааны ургууд бид өөрийн Монголжин дураар аж төрөн, сахилд орох, эс орох нь гагц Мөнх тэнгэр мэднэ. Сахилд орогсод нь таны мэт үнэн сэтгэлт ариун ард, Мөнх тэнгэрийн Христосын ном бишрэн буй заа. Хэдий тийм ч бусад шашинтнууд Мөнх тэнгэрийг умартан худал хулгай үйлдэх нь цөөн биш байна. Намайг сахилд орсонгүй гэж аягүйцэж байна уу. Гагц Мөнх тэнгэрт залбирал зүгээр буй заа.”²¹ гэж дипломат зангаар хариулжээ.

Папаас Аргун хаанд дахин бичиг явуулсан нь түүнийг тэнгэрт хальсны дараа 1291 оны 9 дүгээр сард иржээ. Мөн онд Аргун хааны 3 дугаар хатан Урук зэрэг хүмүүст бичиг ирсэн нь Монгол хаадыг христосын шашинд оруулахыг хичээж Сири, Палестины асуудлыг шийдэхэд Пап онцгой анхаарч байна гэсэн утгатай юм.

1302 оны 4 дүгээр сард Ил хаан Аргуны хүү Газан хаанаас Ромын Пап VIII Бонифаст илгээсэн бичгийн утга нь эцэг Аргуны санааг гүйцээж, христос шашинтай хүч хавсран Египетийг байлдан эзлэх, Мөнх тэнгэрт залбиран үйлээ нэг зүг болгоё. Та цэргүүдээ засагтун гэжээ. Папын элч Бисхарунаар илгээсэн дуртгал үгс хүрч ирснийг уламжлаад хариуг нь Хөхдэй, Бисхарун, Түмэн гурваар буцаан илгээв гээд бичгээ зарлиг хэмээн нэрлэсэн байна.²²

1305 онд Газаны дүү Өлзийт султанаас Францын IV гоо Филиппт илгээсэн захидлын талаар тусгайд нь өгүүлэх бөлгөө.

Ил хаан Хүлэгү болон түүнийг залгамжлагчид тухайн үеийн улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс нөхцөл байдалд тохируулан шашинд янз бүрээр хандаж байв. Хүлэгү, Абага, Аргун хааны үед гадаад бодлогын улмаас зайлшгүй христос шашныг дэмжин, тэдний дунд нэр хүнд олж авах хэрэгтэй байсан бол Газан, Өлзийт султаны үед ноёрхлоо хэвээр хадгалах зорилгын үүднээс нутаг орны ард олны санал сэтгэлийг татах, гол нь Ираны ихэс дээдэс язгууртнуудын эрх ашигтай зохицохын тулд лалын шашинд орж, лалын мөргөлийг төрийн шашин болгон зарлаж байсан юм. Түүхч И.де Ракевильц “Папаас Их хаадад довтолгосон элч нар” бүтээлдээ: “Өрнөдийн гүрнүүдийг талдаа татах гэсэн Хүлэгүгийнхний оролдлого нь амжилт багатай байв. Иймээс дорно дахины христос шашинтнуудын дунд Хүлэгү, түүний хатан Догуз нар өөрсдийгөө Шинэ Константин, Елена хэмээн зарласан байна. Хүлэгүг залгамжлан хааны ор суусан Абага нь бурханы шашинтай байсан хэдий ч тэрбээр христос шашныг дэмжих бүрэн үндэс

²¹ Товуу. Уйгаржсин монгол үсгийн дурсгалт бичгүүд. Хөх хот., 1984, 131 дэх тал

²² Мөн тэнд 134 дэх тал

байсан юм. Византын хаан VIII Михайл Палеологийн охин Мария Абага хааны хатан байснаас гадна эх Догуз хатан ч христосын шүтлэгтэн байсан билээ”²³ гэжээ.

Ил хаадын улс оршин тогтносон бүхий л үеийнхээ туршид элчин харилцаагаа өргөжүүлэн ялангуяа Өрнөд Европын орнуудтай элч төлөөлөгчөө харилцан илгээж, улс төрийн талаар идэвхтэй хамтран ажиллаж байжээ. Ил хаад Монгол гүрний Өрнөд Европтой харилцаж байсан гадаад харилцааг баяжуулан өргөжүүлсэн байна. Тиймээс Ил хаадын оролцоогүйгээр Ойрхи болон Дундад Дорнодод олон улсын харилцааны ямарваа нэгэн асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байлаа. Ил хаад бол өөрсдийнхөө захиран суусан ард түмний эрх ашгийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулан, хоёр фронтод цэрэг байлдааны ажиллагаа явуулж байв. Төрийнхөө тусгаар тогтнолыг хангахад Өрнөд Европтой холбоотны харилцаатай байхад анхаарсан нь Алтан Ордын улсаас сүрдэж байсан Өрнөд Европын хувьд ч нийцтэй байв. Ил хаадын улсын сүүлчийн хаадын үед гадаад зөрчлөө ихээхэн зөөлрүүлэх бодлого баримтлан “тулган шаардах”, “хүчээр түрээ барих” бодлогоосоо татгалзан олон улсын харилцаанд энх тайвны санал, сэдэл гаргах болсон байна.

1342 оны 8 дугаар сард Юань гүрний сүүлчийн Их хаан Тогоонтөмөрт бараалхахаар Ромын Папын онц элч Ионаор (John) удирдуулсан 32 төлөөлөгчид Хан балгаст (Бээжинд) иржээ.²⁴ Тогоонтөмөр хаан тэднийг Папын элч нар хэмээн ихэд хүндэтгэн үзэж баяр ёслолтойгоор Шанду хот дахь өөрийн зуны өргөөндөө хүлээн авчээ.²⁵ Папын элч их хаанд үнэ цэнэтэй бэлэг сэлт, түүний дотор “тэнгэрийн аргамаг хүлэг” дүрсэлсэн уран зураг гардуулжээ.²⁶ Зураач их хааныг тэнгэрийн хүлэгтэй зүйрлэсэн байна. Түүхч И. де Ракевилль бичихдээ: Энэ зураг XIX зууны эх хүртэл Манжийн хааны зуны ордны хаадын цуглуулагт хадгалагдаж байгаад магадгүй 1860 онд шатсан байх. Учир нь англи-францын цэргүүд Бээжинг довтлоход ордныг шатаасан юм.”²⁷ гэжээ.

Их хаан Тогоон-төмөр Ромын Папын элч төлөөлөгчдийг нутаг буцахад нь Пап ламтанг ихэд хүндэтгэн үздэгээ илэрхийлж түүнд алт, мөнгө, хатгаж шаглаж оёсон алтадмал хувцас, торгон нэхмэл, тансаг үнэртэн, хүдрийн заар тэргүүтнийг бэлэг болгон илгээсэн байна.²⁸

²³ Rachewiltz I.de. *Papal Envoys to Great Khans*. London.,1971, p. 91

²⁴ Rachewiltz I.de. etc.p.107

²⁵ Ibid p. 108

²⁶ Ibid p. 109

²⁷ Ibid p. 110

²⁸ Ibid p. 111

Ион тэргүүтэй элч төлөөлөгчид Ромын Папаас Монгол гүрэнд ирсэн сүүлчийн элч нар байсан бололтой.

Монголчууд төр улсын тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, аюулгүй байдлаа найдвартай хамгаалах үүднээс өөрсдөөсөө хүчирхэг (хүн амын тоо, эдийн засгийн чадавхи) улс орнуудыг өрсөн бут цохих, дэлхийг нийтээр нь нэг засаг төрийн мэдэл дор төвшитгөн тохинуулах зорилготой өрнөдөд явуулсан цэрэг дайны ажиллагааны амжилтанд дипломат бодлого, элчин харилцаа чухал үүрэг гүйцэтгэжээ.

Монгол гүрний Өрнөдтэй тогтоосон элчин харилцааны талаар түүхч Ал-Маркизи-ад-Дин, Г.А.Масакин, Ибн-Батута, В.Вартана, Григор Акнерц, Жувейни Ата-Малик, Рашид-ад-Дин, нэрт жуулчин Плано де Карпини, Гийом де Рубрук, Марко Поло нар өөрсдийн бүтээл, аян замын тэмдэглэлдээ тусгасны гадна мөн алтан ургийнхны нууц түүх “Монголын нууц товчоо”-нд өгүүлдэг.

XIII-XIV зууны Монгол хаадын Өрнөд рүү илгээсэн дипломат жуух захидал, бичгийг судлах талаар нэрт эрдэмтэн Абел-Ремюза /Abel-Remusat/, И.Я.Шмидт /I.J.Schmidt/, К.Оссон /D'ohsson K./, Х.Ховорт /H.Howorth/, П.Пеллио /P.Pelliot/, Р.Груссе /R.Grousset/, А.Мостэрт /A.Mostaert/, Ф.В.Кливе /F.W.Cleaves/, А.С.Козин нар ихэд анхаарч суурь судалгаанууд хийжээ. Академич Ш.Бира,²⁹ доктор Д.Хүүхэнбаатар³⁰ нар ч бүтээлүүддээ асуудлыг нухацтай авч үзсэн нь бий. Харин доктор Ж.Бор Монголын дипломатын түүхийг судлах үйлсэд тусгайлан зүтгэл гаргаж буй бөгөөд тэрбээр Монголын нэгдсэн улс, эзэнт гүрэн байгуулагдаж оршин тогтнож байсан бүхий л үед дипломат бодлого, элчин харилцаа чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг өөрийн бүтээлдээ дэлгэн харуулжээ.³¹

Эцэст тэмдэглэхэд тухайн үеийн дэлхий дахины нөлөө бүхий улс орнууд Монголын хаадтай харилцах болсон нь үнэн хэрэгтээ Монголын төрийг хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. Нөгөө талаар Евразийн өргөн уудам нутгийн олон улс орныг эрхшээл, нөлөөндөө оруулж Дорно, Өрнийн хэрэгт үлэмж эрх мэдэл бүхий болсон Монгол гүрний оролцоогүйгээр олон улсын харилцааны аливаа нэгэн асуудлыг шийдвэрлэх, тэр зүгээс ямар хандлага байгааг харгалзан үзэхгүйгээр улс хоорондын яриа хэлэлцээр байгуулах нь бэрхтэй болсон явдал энэ үеийн олон улсын

²⁹ Ш.Бира. Монгол гүрний гадаад харилцаа. VI бүлэг. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть, УБ., 1966

³⁰ Д.Хүүхэнбаатар. Монгол гүрний элчин харилцаа. УБ., 1964

³¹ Ж.Бор. Монголын дипломат товчоон. УБ., 1998, Монгол хийгээд Евразийн дипломат шастир. дэд боть, УБ., 2004

харилцааны үндсэн онцлог байсан нь тодорхой байна. Түүнчлэн худалдаа арилжаа, аян жуучлал, шашны нөлөө тархалт, мэдээлэл, харилцаа холбоо урьд өмнө байгаагүй хөгжин цэцэглэх үүд нээгдсэн нь монголчуудын тогтоосон **Pax Mongolica** буюу “Монголын энх төр”-тэй шууд холбоотой байв. Монголчуудын Евразийн уудам тал нутагт явуулсан цэрэг, дайны ажиллагаа өргөжих тутам урьд нь үл мэдэгдэх олон улс оронтой тулгарахад хүргэж энэ нь чухамхүү анхны **газарзүйн их нээлт** байсан бөгөөд цаашдаа Өрнө, Дорнын хоорондын харилцаа, холбоо хөгжин цэцэглэхийн шийдвэрлэх хүчин зүйл болсон байна.

The Article tells us about objectives of Roman Papa's envoys sent to the Mongolian Great Khans' court. Author embraces time covering from deterrence policy of the Mongolian Khans towards the West to Pax Mongolica period and studies roots of such different attitudes.